ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2025 он


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: О.Нарангарав

Цахим хаяг: narangaravo@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Аудитын санал дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025-02-11 № 1-6/33

танай__________-ны №__________-т

САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ЭНХТАЙВАН ТАНАА

***Өөрчлөлтгүй дүгнэлт***

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

***Дүгнэлтийн үндэслэл***

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

***Асуудлыг онцолсон хэсэг***

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд нийт 29.5 сая төгрөгийн өөрчлөлт орсны 27.8 сая төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 3.2 сая төгрөг нь үнэ төлбөргүй нэмэгдсэн, 0.2 сая төгрөг нь дахин үнэ тогтоож бүртгэлд авсан хөрөнгө байгаа бөгөөд 1.8 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хассан байна.

***Аудитын гол асуудал***

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг зөрчин хичээл үйлдвэрлэлийн зардлаас ном авч хурлын төлөөлөгч нарт бэлэглэсэн байна.

***Бусад асуудлын хэсэг***

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

010020261

***Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага***

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

***Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага***

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **20,784,680.16** | **15,043,568.37** |
| **33** | **АВЛАГА** | 14,096,554.16 | 5,685,942.37 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 924,285.28 | 1,813,673.49 |
| **335** | **Бусад авлага** | 13,172,268.88 | 3,872,268.88 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 3,872,268.88 | 3,872,268.88 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6,688,126.00 | 9,357,626.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 6,688,126.00 | 9,357,626.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,054,800.00 | 4,724,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,593,326.00 | 4,593,326.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 40,000.00 | 40,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,578,428.52** | **65,657,029.82** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 41,578,428.52 | 65,657,029.82 |
| **392** | **Биет хөрөнгө** | 41,417,095.10 | 65,583,696.36 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 27,111,111.14 | 27,111,111.14 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,694,444.46) | (5,083,333.38) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 9,750,680.00 | 33,565,700.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,174,799.44) | (3,507,545.23) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,351,980.15 | 14,998,664.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,977,432.29) | (1,550,901.07) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,000,000.00) | (4,000,000.00) |
| 39217 | Ном | 50,000.00 | 50,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 161,333.42 | 73,333.46 |
| 39301 | Програм хангамж | 352,000.00 | 352,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (190,666.58) | (278,666.54) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **62,363,108.68** | **80,700,598.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **765,540.00** | **71,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 765,540.00 | 71,000.00 |
| **413** | **Өглөг** | 765,540.00 | 71,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 26,000.00 | 71,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 45,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 26,000.00 | 26,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **61,597,568.68** | **80,629,598.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 61,597,568.68 | 80,629,598.19 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,768,306.99 | 11,768,306.99 |
| 51101 | Өмч: - төрийн | 11,768,306.99 | 11,768,306.99 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 49,829,261.69 | 68,861,291.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 49,829,261.69 | 50,567,801.69 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 18,293,489.51 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **62,363,108.68** | **80,700,598.19** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **279,731,686.90** | **353,947,828.91** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **3,439,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **3,439,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 3,439,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө | | 3,439,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **279,731,686.90** | **350,508,828.91** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **227,306,686.90** | **350,508,828.91** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 227,306,686.90 | 350,508,828.91 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **262,238,363.44** | **335,654,339.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **262,238,363.44** | **335,654,339.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **255,458,363.44** | **316,784,339.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **136,710,130.60** | **213,955,272.42** |
| 210101 | Үндсэн цалин | 76,605,520.98 | 90,251,951.06 |
| 210102 | Нэмэгдэл | 35,781,159.53 | 77,883,005.36 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,120,000.00 | 15,675,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,203,450.09 | 30,145,316.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **19,529,736.10** | **26,389,346.74** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,926,573.02 | 18,268,858.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,154,010.92 | 1,981,897.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 923,208.74 | 1,051,448.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 217,921.69 | 968,148.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,308,021.73 | 4,118,994.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,538,608.92** | **19,993,190.54** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,859,760.00 | 8,297,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,200,000.00 | 5,710,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 700,821.92 | 711,516.54 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 100,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 72,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,778,027.00 | 5,026,674.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 75,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **7,015,500.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | - |
| 210502 | Хоол, хүнс | - | 7,015,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,850,499.99** | **1,114,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,368,000.00 | 1,114,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,652,700.00** | **934,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,652,700.00 | 934,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **69,077,563.00** | **30,379,164.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 68,940,017.00 | 30,289,784.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,296.00 | 89,380.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,099,124.83** | **17,003,865.70** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,573,579.00 | 9,803,467.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,525,545.83 | 7,200,398.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,780,000.00** | **18,870,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **6,780,000.00** | **18,870,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,780,000.00 | 18,870,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **17,493,323.46** | **18,293,489.51** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **17,493,323.46** | **18,293,489.51** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **287,350,455.78** | **354,381,097.79** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **287,350,455.78** | **354,381,097.79** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **60,043,768.88** | **3,872,268.88** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,050,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,993,768.88 | 3,872,268.88 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **227,306,686.90** | **350,508,828.91** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 227,306,686.90 | 350,508,828.91 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **275,875,455.78** | **326,541,097.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **275,875,455.78** | **326,541,097.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **265,003,186.90** | **303,843,828.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **137,337,419.94** | **219,878,077.77** |
| 210101 | Үндсэн цалин | 75,362,004.57 | 83,902,646.08 |
| 210102 | Нэмэгдэл | 36,257,834.28 | 89,007,447.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,120,000.00 | 15,516,205.27 |
| 210104 | Урамшуулал | 16,597,581.09 | 31,451,778.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **21,440,246.04** | **21,356,929.60** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,830,100.00 | 12,951,529.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,536,800.00 | 2,088,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,229,700.00 | 1,702,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 265,446.04 | 426,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,578,200.00 | 4,187,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,642,487.92** | **15,594,415.54** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,448,760.00 | 5,498,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 5,520,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 696,421.92 | 711,516.54 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 72,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,997,306.00 | 3,791,999.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,666,990.00** | **4,554,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 249,990.00 | 3,150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,417,000.00 | 1,404,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,652,700.00** | **934,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,652,700.00 | 934,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **77,400,543.00** | **23,441,859.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 77,262,997.00 | 23,352,479.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 74,250.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,296.00 | 89,380.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,862,800.00** | **18,084,447.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,862,800.00 | 18,084,447.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,872,268.88** | **22,697,268.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **7,000,000.00** | **18,825,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,000,000.00 | 18,825,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,872,268.88 | 3,872,268.88 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,872,268.88 | 3,872,268.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **11,475,000.00** | **27,840,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,475,000.00** | **27,840,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,475,000.00** | **27,840,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 11,475,000.00 | 27,840,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 5,750,000.00 | 20,840,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,725,000.00 | 7,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(11,475,000.00)** | **(27,840,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,768,306.99** | **-** | **49,829,261.69** | **61,597,568.68** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | **-** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,768,306.99** | - | **49,829,261.69** | **61,597,568.68** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | **-** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | **-** |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | **-** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | **-** |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,768,306.99** | - | **49,829,261.69** | **61,597,568.68** |
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **11,768,306.99** | - | **49,829,261.69** | **61,597,568.68** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 738,540.00 | **738,540.00** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | - | **-** | **-** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | **-** |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | **-** |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | **-** |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | **-** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 18,293,489.51 | **18,293,489.51** |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,768,306.99** | **-** | **68,861,291.20** | **80,629,598.19** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **376,237,200.00** | **350,508,828.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **376,237,200.00** | **350,508,828.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **357,367,200.00** | **331,683,828.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **236,358,600.00** | **219,878,077.77** |
| 210101 | Үндсэн цалин | 91,688,000.00 | 83,902,646.08 |
| 210102 | Нэмэгдэл | 91,172,600.00 | 89,007,447.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,024,000.00 | 15,516,205.27 |
| 210104 | Урамшуулал | 46,474,000.00 | 31,451,778.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **24,130,000.00** | **21,356,929.60** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,431,600.00 | 12,951,529.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,373,600.00 | 2,088,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,026,900.00 | 1,702,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 510,700.00 | 426,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,787,200.00 | 4,187,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,873,600.00** | **15,594,415.54** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,500,000.00 | 5,498,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,521,600.00 | 5,520,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 780,000.00 | 711,516.54 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 72,000.00 | 72,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000.00 | 3,791,999.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **32,500,000.00** | **32,394,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,000,000.00 | 23,990,000.00 |
| 210602 | Тавилга | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 1,404,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,000,000.00** | **934,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 934,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **25,505,000.00** | **23,441,859.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,250,000.00 | 23,352,479.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 125,000.00 | 89,380.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,000,000.00** | **18,084,447.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,000,000.00 | 18,084,447.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,870,000.00** | **18,825,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **18,870,000.00** | **18,825,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,870,000.00 | 18,825,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **376,237,200.00** | **350,508,828.91** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **376,237,200.00** | **350,508,828.91** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 376,237,200.00 | 350,508,828.91 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **4.00** | **4.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2.00 | 2.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **3,872,268.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **3,872,268.88** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **3,872,268.88** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **3,872,268.88** |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | **-** | 3,872,268.88 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **3,872,268.88** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **3,872,268.88** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | **-** | 3,872,268.88 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагна
лын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор О.Нарангарав гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн батлагдсан төсөв 346.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.7.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Учир нь тайлант оны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасныг зөрчин хичээл үйлдвэрлэлийн зардлаас 675.8 мянган төгрөгөөр ном худалдан авч хурлын төлөөлөгч нарт бэлэглэсэн байна.

### 3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс 72.8 сая төгрөгийн 45 тушаал шийдвэрээс 8.4 сая төгрөгийн 10 тушаал шийдвэр хугацаа хоцорч байршсан байна.

Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 408.5 сая төгрөгийн 25 мэдээллийн бүрэн байршуулсан байна. Мэдээлэл байршуулсан хэрэгжилт 100%-тай, хугацаа хоцролт 85.7%-тай байна.

### 3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 3.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант эхний 9 сарын санхүүгийн тайлан, баримтад завсрын аудитыг хийн, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй байх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, бүрэн хөтлөөгүй байх, цалингийн тооцооллыг НББ-д буруу тайлагнасан байх, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байх, төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байх зэрэг 5 горим сорилыг хэрэгжүүлж төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан.

### 3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн аудитын шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3: Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100% |
| Албан шаардлага | 1 | 4,165.9 | 1 | 4,165.9 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **4,165.9** | **1** | **4,165.9** | **100%** |

### 3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.0 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 8.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 0.6 сая төгрөгийн зөрчилд 0.6 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөв.

**Аудитын явцад залруулсан алдаа:**

1. Худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалд 3.2 сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үр дүнгийн тайланд 1.2 сая төгрөгөөр дутуу, НДШ-ийн өглөгийн эхний үлдэгдэл нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдлээс 0.7 сая төгрөгөөр илүү бүртгэлийг тайлант оны зардлаар бүртгэсэн зэрэг алдааг тус тус залруулав.

2. Цалингаас суутгасан ХХОАТ-ын 0.6 сая төгрөгийн илүү төлөлтийг дутуу тайлагнасан, үр дүнгийн тайлангаарх цалингийн зардлыг 1.3 сая төгрөгөөр зөрүүтэй, ажил олгогчийн НДШ-ийн зардал 1.4 сая төгрөгийн цалингийн зардалд бүртгэсэн зэрэг алдааг тус тус залруулав.

### 4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой**

*Илрүүлэлт:*

Тайлант оны батлагдсан төсвийн хичээл үйлдвэрлэлийн зардлаас 675.8 мянган төгрөгөөр ном худалдан авч хурлын төлөөлөгч нарт бэлэглэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 ”Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах хориглоно” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн албан шаардлага*:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн, батлагдсан төсвийн зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгийн зардал ҮХ-н элэгдэл, ӨТ-ийг буруу бүртгэсэн | 1 | 5,044.8 | - | - | 1 | 5,044.8 | 1 | 5,044.8 | - | - | - | - |
| Цалин, НДШ-ийн зардлыг буруу бүртгэсэн | 1 | 3,306.7 | | | 1 | 3,306.7 | 1 | 3,306.7 | | | | |
| **Дүн** | **2** | **8,351.5** | **-** | **-** | **2** | **8,351.5** | **2** | **8,351.5** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хичээл үйлдвэрлэлийн ном худалдан авч хурлын төлөөлөгч нарт бэлэглэсэн | 1 | 675.8 | - | - | 1 | 675.8 | - | - | | - |
| **Дүн** | **1** | **675.8** | **-** | **-** | **1** | **675.8** | **-** | **-** | | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |